

ТАВАНТОЛГОЙ ХУВЬЦААТ КОМПАНИЙН СУДАЛГАА

КОМПАНИЙН ТАНИЛЦУУЛГА

Тавантолгой ХК нь 45 жил тасралтгүй үйл ажиллагаагаа явуулж байгаа, 200 орчим ажиллагсадтай орон нутгийн өмчтэй хувьцаат компани юм. Жижиг Тавантолгой нэрээр олонд танигдсан энэхүү компани 1995 онд Монголын хөрөнгийн биржид бүртгэгдэж, хувьцаагаа олон нийтэд арилжих эхэлсэн. Тавантолгой ХК нь Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй компаниудаас зах зээлийн үнэлгээ болон ногдол ашиг тогтмол хуваарилдаг байдлаараа тэргүүлдэг. Тавантолгой ХК нь 287A, 11945A гэсэн 2 ашиглалтын лицензтэй, 171.4 га талбайг эзэлдэг бөгөөд одоо ойролцоогоор 90 сая тонн нүүрсний нөөцтэй. /Жич: Тавантолгой ХК-ийн тусгай зөвшөөрөл бүхий талбайд кондиц өөрчлөн нөөцийн дахин тооцоо хийж, Эрдэс баялагийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлэхээр бэлэн болгоод байгаа тул компанийн талбай дахь нөөц их хэмжээгээр өөрчлөгдхө боловжтой.

МЕНЕЖМЕНТ

Тавантолгой хувьцаат компани нь нийт 52,665,200 ширхэг хувьцаа гаргасан. Хувьцаа эзэмшигчдийн эзэмшиж буй хувьцааны талаарх мэдээллийг доорх хүснэгтэнд харуулав.

Хувьцаа эзэмшигчид
Орон нутгийн өмч
Ажны корпораци

Эзлэх хувь
51%
37%

Эх сурвалж: Үнэт цаасны төлбөр тооцоо төвлөрсон хадгаламжийн төв

ТӨЛӨӨЛОН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА - Д. БАТ-ЭРДЭНЭ

Ноён Д.Бат-Эрдэнэ Өмнөговь аймгийн утугуул бөгөөд Тавантолгой ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар 3 жил ажиллаж байгаа бөгөөд “Ажны корпораци”-ийн ерөнхийлөгч, Өмнөговь аймгийн засаг даргын орон тооны бус зөвлөх, “Тавантолгой транс” ХХК-ийн үүсгэн байгуулагч, “Говь барилга” ХХК-ийг үүсгэн байгуулагчю.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ - Х. ТҮМЭНБАЯР

Ноён Х.Түмэнбаяр нь Монгол Улсын Хөдөө Аж Ахуйн Их сургууль, Цэргийн нэгдсэн дээд сургууль, Удирдлагын академийг тус тус хүнд механизмийн инженер, танкны инженер, бизнесийн удирдлага, эдийн засгийн мэргэжлээр дуургэсэн. 1998 оноос 2007 оны хагас хүртэл хувийн хэвшлийн байгууллагад удирдах албан тушаал хашиж байсан. 2007 оны 5 сараас хойш Тавантолгой ХК-ийн гүйцэтгэх захираар томилогдон ажиллаж байна.

САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЭЛ

	2010	2011
Үзүүлэлт		
Нийт хөрөнгө (тэрбум төгрөг)	118.5	115.4
Цэвэр ашиг (тэрбум төгрөг)	76.5	80.1
Биет бус хөрөнгө ба төлбөрийн дүн (тэрбум төгрөг)	18.9	5.8
Нэгж хувьцаанд ногдох ашиг (EPS)	1891	1520
Үнэ ашигийн харьцаа (P/E)	8.22	7.85
Үнэ эзэмшигчийн өмчийн харьцаа(P/B)	6.31	5.73
Нийт хөрөнгийн өгөөж (ROA)	0.64	0.69
Эзэмшигчийн өмчийн өгөөж (ROE)	0.76	0.72
Ноогдол ашиг (төгрөг)	1300	1368
Жилийн дундаж хувьцааны үнэ (төгрөг)	3334	9557
Жилийн дундаж зах зээлийн үнэлгээ (тэрбум төгрөг)	175.9	503.3

Эх сурвалж: Стандарт Инвестмент ХХК


ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Байгуулагдсан он	1967
Үйл ажиллагааны чиглэл	Нүүрс олборлолт
ТҮЗ-ийн дарга	Д. Бат-Эрдэнэ
Нийт хөрөнгө (тэрбум төгрөг)	2011.12.31
	115.4

ХУВЬЦААНЫ МЭДЭЭЛЭЛ

Үнэт цаасны код	458
Символ	TTL
Нийт гаргасан хувьцаа	52,665,200
Хаалтын ханш 2012.08.16 (төгрөг)	10,000

Хувьцааны үз




Арилжаалаагдсан ширхэг




Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭЛЭЛ



Эх сурвалж: <http://mram.gov.mn/>



Эх сурвалж: <http://www.tavantolgoi.mn>

ТАВАНТОЛГОЙ ХУВЬЦААТ КОМПАНИЙН СУДАЛГАА

КОМПАНИЙН ӨСӨЛТ, ХӨГЖИЛ

Тавантолгой ХК нь өмнө нь орон нутгийн болон дотоодын зах зээлд бага хэмжээгээр нүүрсээ борлуулдаг байсан бол 2004 оноос хойш Хятадын зах зээлд экспортлож эхэлжээ. Тавантолгой ХК нь 2010 онд 5.2 сая.тн, 2011 онд 12.3 сая м³ хөрс хуулж, 6.2 сая тонн нүүрсийг олборлож, 214 тн кокс үйлдвэрлэж, нийт 194 тэрбум төгрөгийн борлуулалт хийж, улсын төсөвт 132.2 тэрбум төгрөг төлсөн бөгөөд 2012 онд 6 сая.тн нүүрс олборлон борлуулах төлөвлөгөөг Өмнөговь аймаг, сангийн яамнаас батлуулан авч түүнд тулгуурласан уулын ажлын төлөвлөгөө болон бизнес төлөвлөгөөг боловсруулж байна. Тавантолгой ХК-ийн олборлосон нүүрсийг 2006 оноос хойш Ажнай корпорацийн охин компани болох Тавантолгой транс ХХК-тай хамтран ажиллаж, Өмнөговь аймгийн Цогцэций сумын Тавантолгой нүүрсний уурхайгаас Монгол Улсын Гашуун сухайт - БНХАУ-ын Ганц мод хилийн боомт хүртэл тээвэрлэж байна. 2011 онд ашиглалтын геологи хайгуулан ажил , уурхайн нөөцийн нарийвчилсан үнэлгээг хийлгэж, холбогдох газруудаар хянуулан баталгаажуулж, эрдэс баялагын зөвлөлд оруулан батлуулахаар болов. Уурхайн ашиглалт геологийн нөхцөл өөрчлөгдж, мөн зах зээл дээрх материалын үнийн өсөлттэй холбоотойгоор уулын ажлын зардал нэмэгдэх хандлагатай байгаа учир нүүрсийг боловсруулах талаар судалгаа шинжилгээ хийж байна. Энэхүү төлөвлөсөн төслийн хөрөнгийг санхүүжүүлэхээр ойролцоогоор компанийн хувьцааны 20-30 хувийн хувьцааг нэмж гарахаар шийдвэрлэсэн. Гэхдээ компанийн шинэ хувьцаа гаргах талаар мэдээлэл хараахан ил гаралаа юм. Түүнчлэн, Тавантолгой ХК-ийн хоёр дахь том хувьцаа эзэмшигч Ажнай корпораци нь энэхүү төслийг дэмжиж байгаагаа илэрхийлсэн.

ДҮГНЭЛТ

Тавантолгой ХК нь Монголын томоохон уул уурхайн компаниудын нэг бөгөөд Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй компаниудтай харьцуулахад ногдол ашиг олголт болон зах зээлийн үнэлгээгээрээ тэргүүлж байна. Ногдол ашгийн хувь өндөр байdag учир хөрөнгө оруулагчдын сонирхлыг ихээхэн татдаг. Тавантолгой ХК-ийн хувьцаа Хөрөнгийн бирж дээр идэвхитэй арилжигддаг бөгөөд 2012 оны байдлаар хувьцааны ханш тогтвортой байна. Тавантолгойн нүүрсний IV давхаргын коксжих баяжмалын гарц 66.9%-тай байгаа нь Канад, Австралийн дэлхийн зах зээлд нийлүүлдэг нүүрснээс коксжих чанараараа давуу юм. Уул уурхайн салбарт зөвлөгөө, менежмент, инженерингийн чиглэлээр үйлчилгээ хүргэдэг туршлагаараа дэлхийд танигдсан Hatch байгууллагын хийсэн судалгаагаар дэлхийн гангийн үйлдвэрлэл Хятад, Энэтхэгийн эрэлттэй холбоотойгоор жил бүр 5.2%-иар өсч, коксжих нүүрсний эрэлт одоогоор дэлхийн зах зээл дээр 250-300 сая тонн байгаа бөгөөд 2015 он гэхэд 115 сая тонноор нэмэгдэх хандлагатай байна гэж таамаглажээ. Энэ нь дэлхий дээр гангийн хэрэгцээ нэмэгдсээр байгаа энэ үед дэлхийн зах зээлд коксжих нүүрсний эрэлт их, улмаар үнэ хэт буурахгүй, тогтвортой байхыг илтгэж байна. Өнгөрсөн онуудын санхүүгийн тайлангийн үзүүлэлтэд шинжилгээ хийхэд хөрөнгийн өгөөж (ROA) нь 2010 оныхтой харьцуулахад 4%-иар өссөн нь компанийн хөрөнгийн ашиглалт сайжирсаныг харуулж байна. Бидний үзэж байгаагаар Тавантолгой ХК нь нүүрсээ их хэмжээгээр олборлож, арай илүү үнээр борлуулж, экспортоо нэмэгдүүлбэл компанийн ашигт ажиллагаа сайжирч, хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг илүү их олгох боломжтой гэж үзэж байна.

МОНГОЛ	АНГЛИ	ТАЙЛБАР	ЖИШЭЭ
НЭГЖ ХУВЬЦААНД НОГДОХ АШИГ	EARNING PER SHARE - EPS	<p>Нэгж хувьцаанд ногдох ашиг нь эргэлтэнд байгаа нэгж хувьцаанд ногдох буй цвэр ашигийн хэмжээ юм. Энэ харьцаа компанийн ашигт ажиллагааны чухал үзүүлэлт болдог. Нэгж хувьцаанд ногдох буй ашигийн харьцаа нь нэгж хувьцаанд олгос ногдол ашигийн хэмжээ биш юм. Ихэнх тохиолдолд EPS-н тодорхой хувийг ногдол ашигт олгодог байна.</p>	<p>Нэгж хувьцаанд ногдох ашиг тооцохдоо дараах томъёогоор тооцно.</p> $\text{Нэгж хувьцаанд} = \frac{\text{Цвэр ашиг} - \text{Давуу эрхийн хувьцааны НА}}{\text{Дундаж гаргасан хувьцааны тоо}}$ <p>Тавантолгой ХК-ийн 2011 оны санхүүгийн тайланд тусгагдсанар тайлант үсийн цвэр ашиг 80,057,983,500 төгрөг, дундаж гаргасан энгийн хувьцааны тоо 52,665,200 ширхэг бөгөөд тус компани давуу эрхийн хувьцаа гаргаагүй болно. Нэгж хувьцаанд ногдох ашигийг дараах байдлаар тооцно.</p> $\text{Нэгж хувьцаанд} = \frac{80,057,983,500}{52,665,200} = 1520.13 \text{ төгрөг}$
ҮНЭ БА АШГИЙН ХАРЫЦАА	PRICE TO EARNING RATIO - P/E RATIO	<p>Үнэ ашигийн харьцааг хувьцааны зах зээлийн үнийг нэгж хувьцаанд ногдох ашигийн хэмжээнд хувааж тооцох ба энэ харьцаа нь компанийн 1 төгрөгийн орлогыг зах зээл хөрөнгө оруулагчид хэдэн төгрөгөөр үзүүлж худалдан авахад бэлэн байгааг илрхийлдэг.</p>	<p>Үнэ ашигийн харьцааг тооцохдоо дараах томъёогоор тооцно.</p> $\text{Үнэ ашигийн харьцаа} = \frac{\text{Зах зээлийн үнэ}}{\text{Нэгж хувьцаанд ногдох ашиг}}$ <p>2011 оны сүүлээр Тавантолгой ХК-ийн нэгж хувьцааны зах зээлийн үнэ 10500 төгрөг, изгж хувьцаанд ногдох ашиг 1520.13 төгрөг байсан бол үнэ ба ашигийн харьцааг дараах байдлаар тооцно.</p> $\text{Үнэ ба ашигийн харьцаа} = \frac{10700}{1520.13} = 7.04$
ДАНСНЫ ҮНЭ	BOOK VALUE	<p>Дансны үнэ гэдэг бол тухайн компани үйл ажиллагаагаа зогсоолоо гэхдэгтэй нэгж хувьцаанд ногдох хувийг тодорхойлно. Мөн дансны үнийг зах зээлийг үнэтэй харьцуулж хувьцааны үнэлгээг мэдэж болно.</p>	<p>Дансны үнийг тооцохдоо дараах томъёогоор тооцно.</p> $\text{Дансны үнэ} = \frac{\text{Нийт хөрөнгө} - \text{Биет бус хөрөнгө ба өр төлбөр}}{\text{Дундаж гаргасан хувьцааны тоо}}$ <p>Тавантолгой ХК-ийн 2011 оны санхүүгийн тайланд тусгагдсанар нийт хөрөнгө 115,497,928,700 төгрөг, өр төлбөр 5,822,301,200 төгрөг байна. Дансны үнийг дараах байдлаар тооцно.</p> $\text{Дансны үнэ} = \frac{115,497,928,700 - 5,822,301,200}{52,665,200} = 2082.5 \text{ төгрөг}$
ҮНЭ БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧИЙН ХАРЫЦАА	PRICE TO BOOK RATIO - P/B RATIO	<p>Нэгж хувьцааны зах зээлийн үнийг дансны үнэд харьцуулснаар тухайн компанийн хувьцааны үнэ ондөр эсвэл бага үнэлгэдсэнгүй харуулна.</p>	<p>Үнэ ба эзэмшигчдийн өмчийн харьцааг тооцохдоо дараах томъёогоор тооцно.</p> $\text{P/B харьцаа} = \frac{\text{Зах зээлийн үнэ}}{\text{Нийт хөрөнгө} - \text{Биет бус хөрөнгө ба өр төлбөр}}$ <p>2011 оны сүүлээр Тавантолгой ХК-ийн нэгж хувьцааны зах зээлийн үнэ 10500 төгрөг, изгж хувьцаанд ногдох ашиг 1520.13 төгрөг байсан бол үнэ ба ашигийн харьцааг дараах байдлаар тооцно.</p> $\text{P/B харьцаа} = \frac{10700}{2082.5} = 5.14$
ХӨРӨНГИЙН ӨГӨӨЖ	RETURN ON ASSET	<p>Хөрөнгийн өгөөж нь нийт хөрөнгийн нэг төгрөг тутамд ногдох байгаа цвэр ашигийн хэмжээг илрхийлнэ. Тухайн хөрөнгийг ашиглан олсон цвэр ашигийн хэмжээ ондөр байх тусам өгөөж сайн байна.</p>	<p>Хөрөнгийн өгөөжийг тооцохдоо дараах томъёогоор тооцно.</p> $\text{Хөрөнгийн өгөөж} = \frac{\text{Цвэр ашиг}}{\text{Нийт хөрөнгө}}$ <p>Тавантолгой ХК-ийн 2011 оны санхүүгийн тайланд тусгагдсанар нийт хөрөнгө 115,497,928,700 төгрөг, цвэр ашиг 80,057,983,500 төгрөг байна. Хөрөнгийн өгөөжийг дараах байдлаар тооцно.</p> $\text{Хөрөнгийн өгөөж} = \frac{80,057,983,500}{115,497,928,700} = 69 \%$
ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧИЙН ӨГӨӨЖ	RETURN ON EQUITY	<p>Энэ харьцаа нь хувьцаа эзэмшигчдийн хөрөнгийн нэг төгрөг тутамд ногдох буй ашигийн хэмжээг илрхийлнэ. Өөрөөр хэлбэл, компани хөрөнгө оруулагчдын мөнгийг ашиглан хэр ашиг олж байгааг илрхийлнэ. Энэ харьцаа их байх тусам сайн.</p>	<p>Эзэмшигчдийн өмчийн өгөөжийг тооцохдоо дараах томъёогоор тооцно.</p> $\text{Эзэмшигчдийн өмчийн өгөөж} = \frac{\text{Цвэр ашиг}}{\text{Эзэмшигчдийн өмч}}$ <p>Тавантолгой ХК-ийн 2011 оны санхүүгийн тайланд тусгагдсанар эзэмшигчдийн өмч 109,675,627,500 төгрөг, цвэр ашиг 80,057,983,500 төгрөг байна. Хөрөнгийн өгөөжийг дараах байдлаар тооцно.</p> $\text{Эзэмшигчдийн өмчийн өгөөж} = \frac{80,057,983,500}{109,675,627,500} = 73 \%$

МЭДЭГДЭЛ

Энэхүү судалгааг зөвхөн мэдээлэл өгөх зорилгоор бэлдсэн бөгөөд бүх мэдээллийг найдвартай, сайн санааны үүднээс гаргасан гэж үзсэн эх сурвалжаас авч боловсруулсан хэдий ч мэдээлэл тус бүрийг нэг бүрчлэн хянаж шалгаагүй болно. Тиймээс Стандарт Инвестмент ХХК нь эдгээр мэдээллийн үнэн зөв, бодит бөгөөд бүрэн бүтэн байдалд баталгаа гаргахгүй бөгөөд мэдээллийг дамжуулахаас үссэн аливаа алдааг хариуцахгүй. Түүнчлэн, энэхүү мэдээллийг ашигласнаас учирсан аливаа хохиролд Стандарт Инвестмент ХХК ямар нэгэн хариуцлага хүлээхгүй.

Энэхүү мэдээлэл нь ямар нэгэн үнэт цаасыг худалдан авах, худалдах санал буюу хөрөнгө оруулалтын зөвлөгөө биш юм. Энд дурдсан үнэ ханшийн мэдээ, бусад тоон мэдээлэл, тайлбар зэрэг нь зөвхөн тухайн мэдээллийг бэлтгэх үеийн байдлыг илтгэх бөгөөд өөрчлөгджэй, хувьсаж болно /Стандарт Инвестмент ХХК өөрчлөлтийг мэдэгдэх албагүй/. Мэдээллийг зөвхөн хаягласан хувь хүн болон албан байгууллагын хэрэгцээнд зориулсан ба Стандарт Инвестмент ХХК-ийн зөвшөөрөлгүйгээр мэдээллийг ямар нэгэн хэлбэрээр цааш нь дамжуулах, түгээх, хуулбарлахыг хориглоно.

Хаяг:

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
1-р хороо, Жигжиджавын гудамж 5/3
Утас: (976) 70114433
Факс: (976) 70114433
Вэбсайт: www.standardinvestment.mn

Цэдэвжав ЧИМГЭЭ
АНАЛИСТ